



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/06.

Улаанбаатар хот

Төрийн үйлчилгээний албан хаагчдын
мэргэшлийн түвшинг үнэлэхэд мөрдөх
журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоол, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дугаар тушаалын хавсралт, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоол, тус газрын Дүрмийн 2.3, Хөдөлмөрийн дотоод журмын 5.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлэхэд мөрдөх журмыг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн үйлчилгээний албан хаагчдын жилийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн тогтоосон хэмжээгээр ур чадварын нэмэгдэл, олгож байхыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 21 сарын 28 өдрийн
А/ос тоот тушаалын нэгдүгээр хавсралт



Төрийн үйлчилгээний албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэхэд мөрдөх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасны дагуу тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлыг үнэлэхэд энэхүү журам /цаашид журам гэх/-ыг баримтална.
- 1.2. Журмын зорилго нь төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тэдний оруулсан хувь нэмрийг үнэлэхэд оршино.
- 1.3. Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшингийн байдалд хяналт тавьж, тухайн жилийн 6, 12 дугаар сарын 25-ны дотор тэдний жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланг газрын хурлаар хэлэлцүүлж үүргийн биелэлтийг тус тус үнэлж дүгнэнэ.

Хоёр. Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлын үр дүнд хяналт тавих тайлагнах

- 2.1. Төрийн үйлчилгээний албан хаагчийн төлөвлөсөн ажлын биелэлтийг явц гүйцэтгэлийн талаар ярилцаж зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.
- 2.2. Төрийн үйлчилгээний албан хаагч үйл ажиллагааныхаа үр дүн мэргэшлийн түвшинг энэхүү журмын хавсралт загварын дагуу хагас бүтэн жилээр гаргаж тайлагнана.

Гурав. Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх

- 3.1. Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг хагас, бүтэн жилээр дүгнэнэ.
- 3.2. Төрийн үйлчилгээний албан хаагчийн хагас бүтэн жилийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын биелэлтэд өгсөн үнэлгээний нийт оноог үндэслэн төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинд дараах үнэлгээг өгнө.

а/. 90-100 оноо авсан бол А буюу Маш сайн

б/. 80-89 оноо авсан бол В буюу Сайн

в/. 70-79 оноо авсан бол С буюу Хангалттай

г/. 60-69 оноо авсан бол Д буюу Дутагдалтай

д/. 0-59 оноо авсан бол Е буюу Хангалтгүй

3.3. Нийт ажил үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэсэн ажилд 0-30 оноо, тусгай захиалгатай ажил үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэсэн ажилд 0-40 оноо, мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар гүйцэтгэсэн ажилд 0-30 оноо өгч газрын нийт ажил үйлчилгээний чиглэлээр хийсэн ажлын биелэлтийн дундаж оноо газрын тусгай захиалгат ажил үйлчилгээний чиглэлээр хийсэн ажлын биелэлтийн дундаж оноо мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар хийсэн ажлын ажлын биелэлтийн дундаж оноог тус тус гаргана. Дээр дурьдсан үзүүлэлтүүдийн дундаж оноог нэмж нийт дундаж оноо гарна. Ононд тохирсон харгалзах үнэлгээг үсгээр тэмдэглэж бичнэ.

3.4. Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээг үндэслэн Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тус газрын Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

№	Үнэлгээ	Авах арга хэмжээ
1	"А" маш сайн	Мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох
2	"В" сайн	Мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох, зохих шатны сургалтад хамруулах
3	"С" хангалттай	Зохих шатны сургалтад хамруулах, цалинг хэвээр үлдээх
4	"D" дутагдалтай	Зохих шатны сургалтанд хамруулах, цалин хөлсийг бууруулах, ажлаас чөлөөлөх
5	"F" хангалтгүй	Төрийн албанаас халах

3.5. Хагас болон жилийн эцэст төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээг үндэслэн 3 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал цалинг олгож болно.

3.6. Мөнгөн урамшуулал олгох нөхцөл нь "А", "В" үнэлгээ авсан байх

3.7. Мөнгөн урамшууллын хэмжээг тогтоох: Албан хаагчид олгох жилийн үр дүнгийн шагналт цалингийн хэмжээ нь жилд ажилласан ажлын цагийн коэффициент, "Үр дүнгийн гэрээний биелэлт"-ийн үнэлгээ, шагнал олгох сарын тооноос хамаарах бөгөөд дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$\text{ШЦ} = \text{С} * \text{ҮЦ} * \text{Ү} / 100 * \text{К}$$

С - шагналт цалин тооцох сар

ҮЦ - тухайн албан тушаалын үндсэн цалин

Ү - үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээ

К - жилд ажилласан цагийн коэффициент

$\text{К} = \text{тухайн ажилтны жилд ажилласан өдөр} / \text{тухайн жилийн нийт ажлын өдөр}$

3.8. Шагналт цалинг олгохгүй байх нөхцөл:

Жилд ажилласан ажлын цагийн коэффициент ≤ 0.5

Жилийн ажлын үр дүнгийн гэрээний үнэлгээ ≤ 79.9


Тухайн жилд тушаалаар арга хэмжээ авагдсан болон өөрийн буруутай шалтгаанаар болон ажлаас халагдсан

3.9. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдэл 25 хувь хүртэл байна.

3.10. Төрийн үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагааны жилийн тайланг оны эцэст газрын хурлаар хэлэлцүүлнэ.

3.11. Төрийн үйлчилгээний албан хаагч өгсөн үнэлгээг зөвшөөрөхгүй бол үндэслэлээ тайлбарлах, шаардлагатай гэж үзвэл Газрын даргад бичгээр өргөдөл гаргана.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
 даргын 20.11.2014 оны 01 сарын 23 өдрийн
 А/06 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүн
 мэргэшлийн түвшинг үнэлэх загвар

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
 /албан тушаал/ /овог нэр/ -ын ... оны эхний хагас жил,
 жилийн эцсийн /доогуур зурах/ үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшингийн
 үнэлгээний илтгэх хуудас

1.Төрийн үйлчилгээний албан хаагчийн үүргийн биелэлт

Төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн ажлын биелэлт	Үнэлгээ
а/. Нийт ажил үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэх ажил 1. 2. 3. Г.М		
Нийт ажил үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэсэн ажлын биелэлтийн дундаж оноо /0-30 оноо/		
б/. Тусгай захиалгат ажил үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэх ажил 1. 2. 3. Г.М		

Тусгай захиалгат ажил үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэсэн ажлын биелэлтийн дундаж оноо /0-40 оноо/		
в/. Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар төлөвлөсөн ажил		
1.		
2.		
3.		
г.м		
Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар хийсэн ажлын биелэлтийн дундаж оноо /0-30 оноо/		
Нийт дундаж оноо /0-100/		Үнэлгээ үсгээр

2. Тайлангийн баталгаажуулалт
Ажлын гүйцэтгэлээ тайлагнасан төрийн үйлчилгээний
албан хаагч

гарын үсэг

.....
огноо

3. Үнэлгээ өгсөн газрын даргын тэмдэглэл:

4. Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшингийн үнэлгээний баталгаажуулалт

Үнэлгээ өгсөн :

Дарга

.....
Гарын үсэг

Үнэлгээтэй танилцсан:

Албан хаагч

.....
Гарын үсэг

.....
Огноо